БАТЛАВ.
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА П.ЛХАГВАЖАВ

# ГАДНА ТАЛБАЙН ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| | | |
|---|---|---|
| 1 | Үндэслэл | Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны |
| 2 | Захиалагч | Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар |
| 3 | Байршил, зориулалт | Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7-р баг Ахмадын үйлчилгээний төвийн хойд талд |
| 4 | Техникийн ерөнхий шаардлага | Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж нь хүүхэд, өндөр настны онцлогт зориулсан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг тооцсон байна.<br>Тоглоомын талбай: UCS 1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” стандарт.<br>Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж:<br>UCS 1405B:2022 “ Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг тус тус хангасан байна. |
| 5 | Гадна талбайн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн хийцэд тавих шаардлага: | - Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, холбох хэрэгслүүд нь Монгол орны цаг уурын эрс тэс нөхцөлд тохиромжтой, байгаль орчинд нөлөөгүй материалаар хийгдсэн, бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байна.<br>- Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь бүрэн бүтэн, тусгай багаж хэрэглэхгүйгээр тайлж авах боломжгүй байна.<br>- Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь урах, хатгах, хувцас тээглэх эрсдэл учруулахгүй байна.<br>- Эрэг, боолт, бусад түгжих бэхлэх зүйлс нь сулрах болон тайлагдахаас хамгаалагдсан байна.<br>- Хөдөлгөөнт холбоосны хийц нь сулрах мултрахаас хамгаалагдсан анкер боолтоор бэхэлсэн байна.<br>- Бүх түгжээснүүд зэврэлтээс хамгаалагдсан байх ба холбосон эд ангийн зэврэлтийг хамгийн бага хэмжээнд байхаар материалыг сонгоно.<br>- Хөдөлгөөнт хэсгийн холхивч болон тээглүүр нь тослоход амархан байх.<br>- S, C хэлбэрийн болон бүх төрлийн дэгээнүүд битүүлэгдсэн байх шаардлагатай.<br>-Чийрэгжилтийн тоног төхөөрөмжийн будаг, хамгаалалтын химийн бодис нь эрүүл ахуйн шаардлага хангасан, зэврэлт болон элэгдлээс хамгаалагдсан байна.<br>- Тоглоом суурилуулах заавар нь түүний дагалдах бичиг болон санамжид тодорхой бичигдсэн байна. Засвар нь мэргэжлийн бус хүн ойлгохоор энгийн товч, тодорхой байна.<br>Металл хийцэд тавих шаардлага:<br>-Тоног төхөөрөмжийн металл хийц, хэсгүүд нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн байна. Ил төмрөөр тавцан, гулсуур, |

Д.Танорт
Тендер шалгаруулалтын шударга зохион байгуулах ... 2024.01.25.

2024.01.13

шат хийгээгүй байна.
Модон хийцэд тавих шаардлага:
- Хөрсний ялзрал, шавжид идэгдэх зэрэг элэгдлээс хамгаалж, ус чийг тусгаарлах зориулалт бүхий стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.
Креозот, пентахлорофенол, трибутил, цагаан тугалганы исэл, пестицид хэрэглэсэн модыг тоглоомын талбайд хэрэглэхийг хориглоно.

**Тоног төхөөрөмж дээр зөвлөмж болон мэдээллийг тусган байрлуулах шаардлага**:
Тоног төхөөрөмж дээр үндсэн зориулалт, ашиглах насны хязгаар, жин, өндрийн хэмжээ, аюулгүй байдлын мэдээллийг байрлуулна.



*Зураг 9. Тоног төхөөрөмж дээрх санамж, мэдээллийн хэсэг (Жишээ зураг)*

Тоглоом, чийрэгжүүлэх талбайн орох хэсэгт байрлуулах хэрэглэгчдэд өгөх зөвлөгөө, заавар, санамж, сануулга, аюулгүй байдлыг хангах мэдээллийн самбартай байх.




*Зураг 10. Хэрэглэгчдэд зориулсан талбайн мэдээллийн самбар (Жишээ зураг)*

**Бараа материалын тоо хэмжээ**

| № | Тоног төхөөрөмж хэрэгсэл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Техникийн үзүүлэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Нурууны булчин амраах дасгалын төхөөрөмж | ш | 1 | 1600*700*700мм хэмжээтэй, төмөр хийцтэй, хэвлийн хэсэг болон нурууны булчинг чангалах, амраах зориулалттай, хүргэлт суулгалтыг бүрэн хариуцна |
| 2 | Суга савлуур | ш | 1 | Гарын гурван толгойт болон хоёр толгойт булчин чангалах, биеийн тэнцвэр сайжруулах зориулалттай, хүргэлт суулгалтыг бүрэн хариуцна |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Турник | ком | 1 | 3200*126*2420мм, комдоо 3 турник, дээд мөчний чадварыг нэмэгдүүлэх зориулалттай / Тэмээн / , хүргэлт суулгалтыг бүрэн хариуцна |
| 4 | Алхалтын төхөөрөмж | ш | 2 | 1500*1750мм хэмжээтэй, доод мөчний хөдөлгөөнийг сайжруулж, хамтарсан уян хатан байдлыг сайжруулах зориулалттай, хүргэлт суулгалтыг бүрэн хариуцна |
| 5 | Гар, хөл, нурууны багц төхөөрөмж | ком | 1 | 2280*1445*1070мм хэмжээтэй гар, хөл, нурууны дасгалын ком, хүргэлт суулгалтыг бүрэн хариуцна |
| 6 | Чанга яригч | ш | 1 | Bose S1 pro дүйцэхүйц, цэнэгээ 10-аас дээш цаг барина, микрофоны оролттой, bluetooth холболттой, 150w-аас дээш чадалтай, хүргэлтийг бүрэн хариуцна |
| 7 | Хэвлийн булчин чангалах төхөөрөмж | ком | 1 | 1300*1100*600мм хэмжээтэй, нэг ком нь 2 ширхэгтэй, хүргэлт суулгалтыг бүрэн хариуцна |
| 8 | Гарааны төхөөрөмж | ком | 1 | 7000*100мм хэмжээтэй иж бүрэн ком, хүргэлтийг бүрэн хариуцна |

## Б. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ:

- Бараа материалын чанар, тоо хэмжээ, стандарт маркийн дагуу хугацаандаа нийлүүлэгдэж байгаа эсэхэд
- Бараа материал нь чанартай байх
- Гарал үүслийн гэрчилгээтэй эсэхэд хяналт тавьж ажиллах

## В. НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

- Нийлүүлэгч байгууллага нь тоо хэмжээний дагуу чанартай бараа материалыг гэрээний хугацаанд багтаан нийлүүлэх.
- Нийлүүлэгч байгууллага нь тогтоосон байршил тус бүрд тоглоом, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу угсрах ба газарт хөдөлгөөнгүй, бат бэх суурилуулах ажлыг хариуцна.
- Тээвэрлэлтийн зардлыг нийлүүлэгч байгууллага хариуцна.
- Бараа, материалын тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй гэмтэл, элэгдэл хорогдлын зардлыг нийлүүлэгч байгууллага өөрөө хариуцна.
- Бараа материалыг хүлээн авах албан ёсны арга хэмжээнд барааны үйлчилгээг шалгах, нягтлах, турших бүх үйл явц орно.
- Захиалагчаас шалтгаалаагүй засвар, үйлчилгээний зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- Үйлдвэрлэгчийн гаргасан баталгаа худалдан авагчид байх ёстой. Баталгаат хугацаа хүлээн авсан өдрөөс эхлэн 12 сар үргэлжилнэ. Үйлдвэрлэгчээс олгосон урт хугацааны баталгааны хугацаа нь худалдан авагчид өөрчлөлтгүйгээр олгогдох ёстой.
- Нийлүүлэгч нь импортын материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, гэрчилгээ, сертификат хавсаргасан байх. Үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах

нөхцөлд " Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ" лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байх.

БОЛОВСРУУЛСАН: Д.ЛХАГВАСҮРЭН / ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ДУГААР БАГИЙН ТӨЛӨӨЛӨГЧ /

ХЯНАСАН: Б.БАТБИЛГҮҮН / ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГЭМ БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /

Чийрэгжүүлэлтийн талбайн загвар



Чийрэгжүүлэлтийн талбайн төлөвлөлтийн загвар



*Хүснэгт 2. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төрөл /зориулалтаар/*

| | | | |
|---|---|---|---|
|  | Зогсож дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж<br>*(Жишээ зураг)* |  | Сууж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж<br>*(Жишээ зураг)* |
|  | Хэвтэж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж<br>*(Жишээ зураг)* |  | Зүүгдэж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж<br>*(Жишээ зураг)* |

*Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон дасгалын орон зай*

| Зориулалтын төрөл | Радиус /мм/ | Өндөр /мм/ |
|---|---|---|
|  **Зогсох зориулалттай** *(Жишээ зураг)* | 1000 | 2200 |
|  **Суух зориулалттай** *(Жишээ зураг)* | 1000 | 1500 (суудлаас эхэлнэ) |
|  **Зүүгдэх зориулалттай** *(Жишээ зураг)* | 500 | Заасан 2200 өндрөөс дээш багадаа 300 мм зайг нэмнэ.<br><br>Тайлбар: Тоног төхөөрөмж нь нийт өндрөөс дээш багадаа 300 мм сул орон зайтай байна. |
|  **Хэвтэх зориулалттай** (Жишээ зураг) | 1000 | 2200 |